



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/152/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: О.Алтансүх

Утас: 99077045 Цахим хаяг: Altansukho52@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
С.БАТНЯМ ТАНАА Г

2020.02.27 № 1/216

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020176

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга С.Батням танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.18-наас 2020.02.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Алтансүх хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.15-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Сумын хүн амын эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй зарчмаар стандартын дагуу, чанартай тэгш, шударга жигд үзүүлэхэд оршино." гэсэн эрхэм зорилгын дор эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх гэж үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллаж байна.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн ACOLOUS болон цалингийн Payroll программ" программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 31 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд,” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 454340,4 мянган төгрөгөөс тооцон 9086,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19069,7 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	458,7	5,0	-453,7
Бараа материал	69,624,4	72,135,9	2,511,4
Үндсэн хөрөнгө	477,455,5	484,950,2	7494,6
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-70,784,2	-32,465,3	-38318,9
Нийт хөрөнгө	476,754,5	457,684,8	-19,069,7
Өр төлбөр	455,0	00.00	-455,0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	476,299,5	457,684,8	-18,614,6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	476,754,5	457,684,8	-19,069,7

Бараа материалын дансны үлдэгдэл 2511,4 мянган төгрөгөөр өссөн нь эм боох бараа материал болон аж ахуйн бараа материал, бусад хангамжийн бараа материал худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 7494,6 мянган төгрөгөөр өссөн нь 8924,5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2810,0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан ба үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 32465,3 мянган төгрөгөөр тайлант оны элэгдлийн зардлаар нэмэгдэж 99406,3 мянган төгрөг болсон байна.

Биет бус хөрөнгө нь санхүүгийн программ 200,0 мянган төгрөг, газар 7936,0 мянган төгрөгийн өртөгтэй дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 457684,8 мянган төгрөг болж өмнөх оноос 18614,6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 18614,6 мянган төгрөгөөр буурсан өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрт зориулан 447166,3 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 367964,0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 36641,5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМДСангаас 42560,4 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 434089,8 мянган төгрөг буюу 97,1 хувьтай байгаа нь улсын төсвөөс 367964,0 мянга, орон нутгийн төсвөөс 36641,5 мянга, ЭМДСангаас 30948,8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулж 1437,2 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв:

Нэмэлт санхүүжилтийн дансанд 2019 онд сорьц тээвэрлэсэн замын зардал болох 111,1 мянган төгрөг орсныг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 472,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч 1 алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт:

2019 оны 5-р сарын 10-ны өдрийн 24 тоот тушаалаар Р.Гэрэлмаад 472,0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг цалингийн зардлаас гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.5-т “Төсвийн шууд захирагч батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах эрхтэй”, Сангийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 5 дугаар тушаал Эдийн засгийн ангилал батлах тухай 1-т „Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлан, Бараа материалын тайланг цаг хугацаанд нь гаргаж байх

2.13. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллээс хугацаанд нь 129 мэдээллийг , 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Тайлбар
1	Бүтэн жил	11	11	10	1		
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	75	21		
	Нийт	27	151	129	22		

2019 оны тайлант онд Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт мэдээний 1, 5-р сар, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн 1-9 сар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээний 1-9 н сарын мэдээ, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн мэдээг тус тус хугацаа хоцроосон байна.

Хугацаа хоцроосон тайлбарыг нягтлан бодогчоос авахад алдаатай буруу оруулсан мэдээллийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс шалгаж мэдээллийг засуулж оруулснаас хугацаа хоцроосноор бүртгэгдсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сумын ОНХС-гаас багийн эмч нарын уналгад зориулан ,,,, морь худалдан авч өгснийг зарж борлуулан мөнгийг сумын ОНХС-д тушаасан байна. Гэтэл тайлант оны эцэст 1650,0 мянган төгрөгийн мал амьтад данснаас нягтлан бодогч бараа материалын нярвын тайлан гаргаагүй, анхан шатын баримтгүй зарлага гарсан байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд үнэн зөв гаргах

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн тул цаашид бараа материалын тайлан болоод анхан шатны баримтын бүрдлийг цаг тухайд нь бүрдүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,083,214.01	72,140,932.35
33	АВЛАГА	458,756.00	5,015.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	458,756.00	5,015.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69,624,458.01	72,135,917.35
351	Түүхий эд материал	28,641,249.00	29,519,137.00
35110	Тусгай зориулалттай материал	28,526,249.00	28,526,249.00
35130	Эм боох материал	115,000.00	992,888.00
354	Хангамжийн материал	35,500,709.01	38,784,280.35
35410	Бичиг хэргийн материал	1,549,700.00	1,503,910.00
35420	Аж ахуйн материал	31,411,889.01	33,576,394.01
35450	Барилгын засварын материал	00.00	1,026,500.00
35460	Хүнсний материал	1,689,120.00	1,574,976.34
35470	Бусад хангамжийн материал	850,000.00	1,102,500.00
35600	Мал амьтад	5,482,500.00	3,832,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	406,671,300.03	385,543,878.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	406,671,300.03	385,543,878.99
392	Биет хөрөнгө	398,535,300.03	377,407,878.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	344,642,898.29	344,642,898.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,992,800.04	-19,796,979.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,736,434.00	38,736,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,556,072.36	-15,312,144.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78,587,149.00	84,175,049.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-52,103,957.84	-59,227,129.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,353,105.00	9,259,841.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,131,456.02	-5,070,089.90
393	Биет бус хөрөнгө	8,136,000.00	8,136,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,136,000.00	8,136,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	476,754,514.04	457,684,811.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	476,299,508.04	457,684,811.34
51	Засгийн газрын хувь оролцоо	476,299,508.04	457,684,811.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	259,003,817.00	259,003,817.00
51101	Өмч: - төрийн	259,003,817.00	259,003,817.00
512	Хуримтлагдсан үр дүн	-91,499,283.73	-108,925,580.43
51210	Өмнөх үеийн үр дүн	-91,499,283.73	-90,310,883.73
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-18,614,696.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	308,794,974.77	307,606,574.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	476,754,514.04	457,684,811.34

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	394,205,154.00	435,665,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,938,734.00	67,701,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331,908,900.00	367,964,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,769,840.00	111,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,769,840.00	111,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	36,641,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	36,641,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,168,894.00	30,948,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	30,948,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	394,846,805.87	453,943,799.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,846,805.87	453,943,799.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348,584,394.87	452,446,226.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,725,358.00	268,444,171.80
210101	Үндсэн цалин	209,725,358.00	268,435,869.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	8,302.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,066,398.00	33,551,355.00
210201	Тэтгэврийн даатгал	25,066,398.00	33,551,355.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,588,458.00	32,312,005.00
210301	Гэрэл, цахилгаан	3,018,392.00	2,393,473.00
210302	Түлш, халаалт	26,426,066.00	29,821,732.00
210303	Цэвэр, бохир ус	144,000.00	96,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,563,478.00	26,664,184.00
210401	Бичиг хэрэг	1,792,200.00	2,199,240.00
210402	Тээвэр, шатахуун	17,559,983.00	19,943,464.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,179,095.00	2,342,080.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,032,200.00	529,400.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,650,000.00
2105	Нормативт зардал	31,995,556.00	36,545,250.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,146,966.00	30,449,902.20
210502	Хоол, хүнс	4,470,790.00	4,942,103.66
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	377,800.00	1,153,245.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,944,400.00	1,856,396.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	22,000.00
210604	Урсгал засвар	2,944,400.00	1,834,396.00
2107	Томилолт, зочны зардал	560,000.00	752,000.00
210702	Дотоод албан томилолт	560,000.00	752,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,479,200.00	720,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,434,000.00	322,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	344,300.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	53,860.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,661,546.87	51,600,603.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,642,637.00	19,135,290.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,018,909.87	32,465,313.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,262,411.00	1,497,573.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,249,234.00	60,310.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10,248,394.00	60,310.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,329,599.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,329,599.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,177.00	107,664.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,177.00	107,664.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-641,651.87	-18,278,399.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40,909,155.54	396,607.70
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	40,909,155.54	396,607.70
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-40,909,155.54	-396,607.70
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-41,550,807.41	-18,675,006.70

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	393,847,634.00	435,665,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	393,847,634.00	435,665,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331,908,900.00	367,964,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,769,840.00	111,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,769,840.00	111,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	36,641,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	36,641,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,168,894.00	30,948,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	30,948,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	393,804,795.00	435,665,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,804,795.00	435,665,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,735,223.00	434,228,137.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,117,764.00	268,430,169.00
210101	Үндсэн цалин	156,265,488.00	199,615,500.00
210102	Нэмэгдэл	39,462,416.00	53,359,784.00
210104	Урамшуулал	14,389,860.00	15,454,885.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,793,380.00	33,557,300.00
210201	Тэтгэврийн даатгал	16,449,572.00	22,298,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,304,900.00	2,814,600.00

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,974,400.00	2,251,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	574,600.00	562,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,489,908.00	5,629,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,588,458.00	32,312,005.00
210301	Гэрэл, цахилгаан	1,141,586.00	2,722,705.00
210302	Түлш, халаалт	28,302,872.00	29,492,500.00
210303	Цэвэр, бохир ус	144,000.00	96,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,772,059.00	20,894,924.00
210401	Бичиг хэрэг	969,400.00	1,199,260.00
210402	Тээвэр, шатахуун	16,527,259.00	16,531,214.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	877,800.00	2,016,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,397,600.00	1,148,450.00
2105	Нормативт зардал	26,913,590.00	36,136,613.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,400,000.00	31,362,113.00
210502	Хоол, хүнс	5,559,090.00	4,202,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,954,500.00	571,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,624,300.00	6,904,896.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,170,000.00	2,505,000.00
210602	Тавилга	00.00	1,400,000.00
210604	Урсгал засвар	2,454,300.00	2,999,896.00
2107	Томилолт, зочны зардал	560,000.00	752,000.00
210702	Дотоод албан томилолт	560,000.00	752,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,858,008.00	509,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,769,000.00	111,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	398,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,507,664.00	34,730,970.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,507,664.00	34,730,970.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,069,572.00	1,437,263.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,329,599.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,329,599.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,177.00	107,664.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,177.00	107,664.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,003,817.00	308,794,974.77	-91,499,283.73	476,299,508.04
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,003,817.00	308,794,974.77	-91,499,283.73	476,299,508.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,188,400.00	1,188,400.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,003,817.00	308,794,974.77	-90,310,883.73	477,487,908.04
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,188,400.00	00.00	-1,188,400.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,614,696.70	-18,614,696.70
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,003,817.00	307,606,574.77	-108,925,580.43	457,684,811.34

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	447,166,300.00	434,089,806.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	447,166,300.00	434,089,806.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	447,166,300.00	434,089,806.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,457,800.00	268,430,169.00
210101	Үндсэн цалин	199,615,500.00	199,615,500.00
210102	Нэмэгдэл	53,371,900.00	53,359,784.00
210104	Урамшуулал	15,470,400.00	15,454,885.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,557,300.00	33,557,300.00
210201	Тэтгэврийн даатгал	22,298,900.00	22,298,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,814,600.00	2,814,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,251,700.00	2,251,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	562,900.00	562,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,629,200.00	5,629,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,641,500.00	32,312,005.00
210301	Гэрэл, цахилгаан	3,049,000.00	2,722,705.00
210302	Түлш, халаалт	29,492,500.00	29,492,500.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	96,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,616,600.00	20,894,924.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,199,260.00

210402	Тээвэр, шатахуун	18,400,600.00	16,531,214.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	2,016,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,148,450.00
2105	Нормативт зардал	42,238,400.00	36,136,613.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,322,500.00	31,362,113.00
210502	Хоол, хүнс	6,900,000.00	4,202,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,015,900.00	571,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,905,000.00	6,904,896.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,505,000.00	2,505,000.00
210602	Тавилга	1,400,000.00	1,400,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	2,999,896.00
2107	Томилолт, зочны зардал	1,820,000.00	752,000.00
210702	Дотоод албан томилолт	1,820,000.00	752,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00	398,160.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	398,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36529700.00	34703739.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,529,700.00	34,703,739.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	447,166,300.00	434,117,037.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	367,964,400.00	367,856,336.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,964,400.00	367,856,336.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,641,500.00	35,311,901.00
132001	Орон нутгийн төсвөөс	36,641,500.00	35,311,901.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,560,400.00	30,948,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42,560,400.00	30,948,800.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00


Аудитын тайланг

Хяансан:

Тэргүүлэх аудитор  Б.Мөнхбат 2018.02.24

Аудитын менежер  А.Цээням 2018.02.24

Бэлтгэсэн:

Аудитор  О.Алтансүх 2018.02.24

